



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 21 өдөр

Дугаар А/58

Амардалай

Хорио цээрийн дэглэмийг
хязгаарлалтын дэглэмд шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, 18.1 дэх заалт, Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 22 -ний өдрийн 266 дугаар тогтоол "Хорио цээр, хязгаарлалтын дэглэм"-ийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Тус Цахиурт багийн "Өлгий" нэртэй газрын голомтын бүсийн малд сүүлчийн өвчилсөн малаас хойш малын гоц халдварт бог малын мялзан өвчний эмнэл зүйн шинж тэмдэг малд 21 хоногийн хугацаанд илрээгүй тул сумын Засаг даргын 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн "Хорио цээрийн дэглэмийг сунгах тухай" А/49 дугаар захирамжийг цуцлан, хязгаарлалтын дэглэмд 2022 оны 07 дугаар сарын 21-ний өдрөөс 14 хоногийн хугацаатай хязгаарлалтын дэглэм тогтоосугай.

Хоёр. Голомтын бүсийн хилийн заагт байршуулсан байнгын 1, хөдөлгөөнт 2 постыг үргэлжлүүлэн ажиллуулахыг Шуурхай штабын дарга (С.Нарантунгалаг)-д даалгасугай.

Гурав. Хязгаарлалтын бус нутгийн малд үзлэг тандалт, шинжилгээ, хашаа хороо, уст цэгт төгсгөлийн халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулж ажиллахыг Мал эмнэлгийн нэгжийн эмч (М.Даваацэрэн), (М.Ганьхүү), МЭТ-ийн дарга (Д.Наранцэцэг) нарт үүрэг болгосугай.

Дөрөв. Хязгаарлалтын дэглэм тогтоосон бүсийн хүн, тээврийн хэрэгсэл, малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг 2-р багийн Засаг дарга (Г.Сосорбурам), цагдаа (Б.Ууганбаатар) нарт үүрэг болгосугай.

ДАРГА 

М.БАЯРСҮХ

4880030771